# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр Дугаар 442 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 133,955,366.16 (нэг зуун гучин гурван сая есөн зуун тавин таван мянга гурван зуун жаран зургаан төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 86,493,233.12 (наян зургаан сая дөрвөн зуун ерэн гурван мянга хоёр зуун гучин гурван төгрөг арван хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Жаргалсайхан, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Бат-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132002078

21-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 09 дүгээр сарын ...26...-ны өдрийн
...442... дугаар тогтоолын хавсралт

**"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Түүхий нүүрс тэжээгч зуух ¹9а | 2011/12/31 | комплект | 1 | 66,977,683.08 | 43,246,616.56 | 23,731,066.52 |
| 2 | Түүхий нүүрс тэжээгч зуух ¹9б | 2011/12/31 | комплект | 1 | 66,977,683.08 | 43,246,616.56 | 23,731,066.52 |
| Нийт дүн | | | | | 133,955,366.16 | 86,493,233.12 | 47,462,133.04 |
| | | | | | (нэг зуун гучин гурван сая есөн зуун тавин таван мянга гурван зуун жаран зургаан төгрөг арван зургаан мөнгө) | (наян зургаан сая дөрвөн зуун ерэн гурван мянга хоёр зуун гучин гурван төгрөг арван хоёр мөнгө) | (дөчин долоон сая дөрвөн зуун жаран хоёр мянга нэг зуун гучин гурван төгрөг дөрвөн мөнгө ) |